



## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 4/12

Улаанбаатар хот

Г

Г

### Ажил зохион байгуулах тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, түргэн шуурхай хүртээмжтэй болгох, биеийн тамир, спортын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, харилцан суралцаж туршлага солилцох зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр” –ийг зохион байгуулсугай.
2. “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Дээрхи ажлыг тогтмол зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Г.Бямбасайхан/-д даалгасугай.





Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын  
2016 оны ~~Чартжүүлэсэн~~ Ажил танилцуулсан 09-ны өдрийн  
~~A/10/...~~ дугаар тушаалын хавсралт  
3279 907446

**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР, СПОРТ ХОРООДЫН  
ХАМТ “АЖИЛ ТАНИЛЦУУЛАХ, ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ӨДӨР”-ИЙГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

№	Сарууд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1	Нийслэлийн БТСГ				X	X					X	X	
2	БГД										X		
3	БЗД						X						
4	БНД					X							
5	БХД								X				
6	СХД										X		
7	СБД											X	
8	ХУД									X			
9	ЧД					X							
10	НД										X		

**Тавигдах шаардлага:**

- Дүүргийн Биеийн тамир, спортын хороод “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас батлагдсан хуваарийн дагуу тушаал, хөтөлбөр, төлөвлөгөө гарган чанарын өндөр түвшинд зохион байгуулж зурагжуулсан тайлан, бусад холбогдох материалуудыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт З хоногт багтаан цахимаар болон албан тоотоор ирүүлнэ.
- “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах байршлыг дүүргийн Биеийн тамир, спорт хороод өөрсдөө тогтооно.
- “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо зохион байгуулахдаа Биеийн тамир, спорт хороонууд, Спортын холбоод, Спортын клубууд, Эрүүл мэндийн нэгдэл, Хамтлаг, ТББ, болон бусад аж ахуй нэгж байгууллагуудыг оролцуулж хамтран ажиллаж өргөн олныг хамруулна.
- Өмнөх онуудад дүүргүүдийн БТСХ-оос зохион байгуулсан “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг гол гол шинэлэг санаа, үр дүнд хүрсэн ажлуудыг туршлага болгон нэвтрүүлсэн байна.

5. Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлж байгаа онцлог, шинэлэг санаа, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг олон нийтэд зурагт үзүүлэн, самбар, презентэйшн, бусад боломжтой нөхцлөөр сурталчилан таниулна.
6. Байгууллагын болон биеийн тамир, спорт, чийрэгжилтийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авч нэгтгэн дүгнэж үнэлэлт дүгнэлт өгч хэрэгжүүлэх санал боловсруулж үйл ажиллагаандaa тусгаж ажиллана.
7. Телевиз, сонин, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр сурталчилаж хамтран ажилласан байна.
8. Тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо нь бусад дүүргийн Биеийн тамир, спорт хороодоос зохион байгуулж байгаа “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-т заавал төлөөлөл оролцуулна.

Тухайн Биеийн тамир, спорт хорооноос зохион байгуулсан “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийн нийт үнэлгээг 2016 оны байгууллагын ажил дүгнэх журамд оруулан тооцно.

**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗАР**